



**МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАР**

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: (976-51) 26 20 46, Факс: (976) 7015 2046,
Цахим шуудан: info@ags.gov.mn,
Цахим хуудас: www.ags.gov.mn

2023.11.30 № 01/1020
танай _____-ны № _____-т

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ц.БАЯРБАТ ТАНАА

Зөвлөмж хүргүүлэх тухай

Манай байгууллагаас Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд 2023 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдаанд танилцууллаа.

Энэ оны эхний хагас жилийн байдлаар Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт дунджаар **61.8** хувь, 2020-2023 оны өссөн дүнгээр **60.0** хувь, Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт дунджаар **45.95** хувь, Монгол Улсын Хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоол болон Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Монгол Улсын Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын албан даалгавар, захирамж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж зэрэг 639 шийдвэрийн 7730 зүйл, заалт (давхардсан тоогоор)-ын хэрэгжилт дунджаар **73.2** хувь байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээс авч үзэхэд, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан нийт арга хэмжээний 4.8 хувь (2020-2023 оны дүнгээр), Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан нийт 201 шалгуур үзүүлэлтийн 12.9 хувь, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн нийт хяналтад авсан 7730 зүйл, заалтын 7.0 хувь тус тус хэрэгжээгүй байна.

Дээр дурдсан бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт үр дүнгүй байгаа нь төлөвлөлтийг суурь судалгаа, тооцоололгүй хийсэн, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв, санхүүжилт батлагдаагүй, мөн үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалттай холбоотой буюу зураг төсөл боловсруулах, тендер шалгаруулах, гэрээ байгуулах, шүүхийн маргаан зэрэг бэлтгэл, урьдчилсан шатны ажил удаашралтай явагдаж байгаагаар холбоотой

15160 0 2681

Боловсруулсан: Д. Дугаа, Ш. Буян и др.
Хянасан: Т. Монхсүрэн
Хувь:

1835 0 03121

байна. Түүнчлэн төлөвлөсөн үр дүндээ хүрээгүй, хийсэн ажил, үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу бүрэн, тодорхой тайлагнаагүйгээс хэрэгжээгүй гэж үнэлэгдсэн байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнд үндэслэн бүрэн хэрэгжсэн, нэг удаагийн шинж чанартай, тухайн байгууллагын чиг үүрэгт хамааралгүй, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон, холбогдох хууль тогтоомжийн үйлчлэл дуусгавар болсон зэрэг нийт 8 төрлийн эрх зүйн баримт бичгийн 544 заалтыг хяналтаас хасах шаардлагатай гэж дүгнэв.

Барилга, хот байгуулалтын яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн дүнг яамдын дундаж дүнтэй харьцуулахад Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 0.8 нэгжээр дээгүүр, Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт 4.2 нэгж, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 1.1 нэгжээр тус тус доогуур байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг үндэслэн Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүргийн дагуу дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх Зөвлөмжийг хүргүүлж байна.

1.Бодлого, арга хэмжээ, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг үр дүнд чиглүүлэн шуурхай удирдан зохион байгуулах талаар:

1.1.хугацаа хоцорсон, хэрэгжилт удаашралтай, хэрэгжээгүй бодлого, зорилт, арга хэмжээ, тогтоол шийдвэрийн зүйл, заалт бүрээр шалтгаан, нөхцөлийг судлан дүгнэлт хийж, төлөвлөсөн хугацаа, үр дүнг тооцоолж, хэрэгжилтийг эрчимжүүлэх, үр дүнд хүргэхэд чиглэсэн арга хэмжээг шуурхай авч ажиллах;

1.2.хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр үүрэгжүүлэн өгсөн шийдвэрийн зүйл, заалт бүрийг хяналтад авч, хэрэгжүүлэх ажлыг бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх үйл ажиллагаатай уялдуулан төлөвлөгөөтэй шуурхай зохион байгуулж ажиллах;

1.3.арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилсан шатны бэлтгэл ажлууд болох тендер шалгаруулалт, судалгаа шинжилгээ хийх, ТЭЗҮ, төсөв, зураг төсөл боловсруулах, хянах, концесс, гэрээ хэлцэл хийх зэрэг ажлыг шуурхай зохион байгуулах, энэ чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай нягт хамтран ажиллах;

1.4.бодлого, арга хэмжээний үндсэн болон хамтран хэрэгжүүлэгч байгууллага хэрэгжилтийн явц, үр дүнг хэлэлцэж, хэрэгжүүлэх, шийдвэрлэх шаардлагатай асуудлыг тодорхой болгож, хэрэгжилтийг хангах;

1.5.бодлого, арга хэмжээний хамтран хэрэгжүүлэгч байгууллага эрхлэх асуудлын хүрээнд үндсэн хэрэгжүүлэгч байгууллагуудад бодлогын болон үйл ажиллагааны тодорхой дэмжлэг үзүүлж ажиллах;

1.6.бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх өөрийн үйл ажиллагаандаа явцын хяналт-шинжилгээг тогтмол хийж, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй байгаа буюу хэрэгжүүлээгүй арга хэмжээ, шийдвэрийн шалтгаан, нөхцөлийг судалж, үнэлэлт, дүгнэлт хийж, шаардлагатай арга хэмжээ авч, үйл ажиллагааг үр дүнд чиглүүлэн удирдан зохион байгуулах.

2.Бодлогын зорилт, арга хэмжээ, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, үр дүнгийн тайлагналтыг сайжруулах талаар:


2.1.бодлогын баримт бичигт тусгагдсан холбогдох арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн заалт, өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг шалгуур үзүүлэлт, заалтын дагуу бүрэн, тодорхой, оновчтой, хэмжигдэхүйц байдлаар тайлагнаж хэвших;

2.2.бодлого, арга хэмжээний үндсэн хэрэгжүүлэгч байгууллага нь хамтран хэрэгжүүлэгч байгууллага болон аймаг, нийслэлээс арга хэмжээний хэрэгжилтийн талаарх холбогдох тайлан мэдээллийг авч, хэрэгжилтийн явц, үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч, үр дүнг нэгтгэн тайлагнах;

2.3.тайлан, мэдээллийг тогтоосон хугацаанд бүрэн, үнэн зөв, шуурхай тайлагнаж, нотлох баримтад тулгуурласан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх боломжийг бүрдүүлэх.

Барилга, хот байгуулалтын яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг хавсаргав.

Хавсралт ... хуудастай.

ДАРГА  Б.БААСАНДОРЖ

9023010230 CTC3950 6975747

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын
2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн
01/10/20 дүгээр албан бичгийн хавсралт

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД
ХАМААРАХ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

Бодлогын баримт бичгийн болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн /new.unelgee.gov.mn/ цахим сангаар дамжуулан ирүүлсэн тайлан мэдээлэлд үндэслэсэн бөгөөд “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2, 6.3, 6.4-т заасан аргачлалыг баримталсан болно.

1) Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 203 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд Барилга, хот байгуулалтын яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах 5 бодлого, 32 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 69 арга хэмжээ тусгагдсан байна.

Эдгээр арга хэмжээний хэрэгжилт 2020-2023 оны дүнгээр 62.2 хувь байна. Нийт арга хэмжээний 8 буюу 11.6 хувь үр дүнд хүрсэн байгаа бол 28 буюу 40.6 хувь тодорхой үр дүнд хүрсэн, 31 буюу 44.9 хувь хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийг бодлого, зорилт тус бүрээр авч үзвэл:

№	Бодлого	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Хэрэгжилт (2020-2023)
1.	Хүний хөгжлийн бодлого	6	7	64.3
2.	Эдийн засгийн бодлого	13	42	60.7
3.	Засаглалын бодлого	3	3	76.7
4.	Ногоон хөгжлийн бодлого	4	7	65.0
5.	Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого	6	10	61.0

Эдийн засгийн бодлого, Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын хүрээнд хамаарах дараах арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай байна.

- Улсын хэмжээнд хот суурингийн төвийн 1:1000-ны масштабтай байр зүйн зураг, газар доорх шугам сүлжээний зургийг солбицлын ITRF2020 эринд шилжүүлэх ажлыг зохион байгуулна.

- Навигацын хиймэл дагуулаас мэдээ хүлээн авах суурин станц /GNSS/-ыг өргөжүүлэх замаар байрлалын сүлжээний нарийвчлалыг 2 см хүртэл сайжруулж, геодезийн хэмжил, зураглалын үйл ажиллагаанд ашиглана.

- Батлан хамгаалах, газар зохион байгуулалт, хот байгуулалт, геологи хайгуул, байгаль орчин, авто зам, төмөр зам зэрэг салбарын эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн Монгол Улсын нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25 000 масштабтай байр зүйн зургаар зурагжуулна.

- Улсын хэмжээнд ашиглагдаж буй барилга, байгууламжийн паспортжуулалт, тэдгээрийн чанар, насжилтыг тодорхойлж, цахим мэдээллийн нэгдсэн санд үнэлгээг оруулна.

- Газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын системийг бий болгож, газрыг хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоог бүрдүүлэн хяналт тавина.

- Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороонд "Ногоон нуур 1008 айлын орон сууц төсөл"-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

- "Солонго 1", "Солонго 2" төслүүдийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

- "Баянголын амны орон сууц" барих төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

- Орлогод нийцсэн 10,000 орон сууцны эко хорооллын төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

- Сонгинохайрхан дүүргийн 6 дугаар хороонд орлогод нийцсэн 740 айлын орон сууцны төсөл хэрэгжүүлнэ.

- Аймгийн төв, суурин газрын 8 цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, шинээр барих төслийг үе шаттай хэрэгжүүлнэ. /Баян-Өлгий, Дорнод, Говьсүмбэр, Завхан, Увс, Говь-Алтай, Баянхонгор аймгуудын төв болон Улаанбаатар хотын Багануур дүүрэг/

- Аймгуудын барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийг техник тоног төхөөрөмжөөр хангана.

- Барилгын материалын сорилт шинжилгээний төв лабораторийг өргөх машин механизм, цахилгаан утасны лаборатори, барилгын физикийн лабораторийн тоног төхөөрөмжөөр хангана.

2) Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт

Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд Хүний хөгжлийн бодлого, Эдийн засгийн бодлого, Иргэн төвтэй хөгжлийг дэмжсэн засаглалын бодлого, Байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах ногоон хөгжлийн бодлого, Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого гэсэн 5 бүлэг, 18 зорилго, 75 арга хэмжээ, мөн эдгээр арга хэмжээнд хамаарах 201 шалгуур үзүүлэлт тусгагдсан.

Уг төлөвлөгөөнд Барилга, хот байгуулалтын яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах нийт 34 арга хэмжээ байгаагаас үндсэн хариуцах 15, бусад яамтай хамтран хэрэгжүүлэх 19 арга хэмжээ байна. Арга хэмжээний хэрэгжилт 48.0 хувь байна.

Үндсэн хэрэгжүүлэх арга хэмжээний шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг авч үзэхэд, 1 шалгуур үзүүлэлт 90.0 хувь буюу үр дүнтэй, 2 шалгуур үзүүлэлт 70.0 хувь буюу тодорхой үр дүнд хүрсэн, 11 шалгуур үзүүлэлт 30.0-50.0 хувь буюу эрчимжүүлэх шаардлагатай, 1 шалгуур үзүүлэлт 0.0 хувь буюу үр дүнгүй үнэлэгдсэн байна.

Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын "Орон нутаг дахь сум, суурин газрын ус хангамж, ариутгах татуурга, инженерийн шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх" арга хэмжээний хэрэгжилтийг төлөвлөсөн арга хэмжээ, шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнаагүйгээс 0.0 хувиар үнэлэгдсэн байна.

Мөн дараах арга хэмжээ 30.0-50.0 хувиар үнэлэгдсэн бөгөөд эдгээр арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх, сайжруулах шаардлагатай байна.

1. [2.4.4] Арматур, хавтгай шил зэрэг үндсэн нэр төрлийн түүхий эдийг дотооддоо үйлдвэрлэх барилгын материалын үйлдвэрүүд барих;

2. [5.1.1.3] Улаанбаатар хотын гэр хорооллыг дахин төлөвлөж, орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх төслүүд хэрэгжүүлэх ("Залуус-1" орон сууцны хороолол барих төслийн явц, хувиар);

3. [5.1.1.4] Улаанбаатар хотын гэр хорооллыг дахин төлөвлөж, орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх төслүүд хэрэгжүүлэх ("Ногоон нуур 1008 айлын орон сууц төсөл"-ийн явц, хувиар);

4. [5.1.1.5] Улаанбаатар хотын гэр хорооллыг дахин төлөвлөж, орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх төслүүд хэрэгжүүлэх ("Солонго-1", "Солонго-2" орон сууцны хороолол барих төслийн явц, хувиар);

5. [5.1.2] Бага, дунд орлоготой иргэдийг орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулах;

6. [5.1.3.2] Шинэ суурьшлын бүс, чөлөөт бүсийн хөгжлийн төлөвлөлтийг боловсруулж, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх (Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг эрэмбэлэн, зураг төслийг боловсруулах объектын тоо);

7. [5.1.5.1] Улаанбаатар хотын ус хангамж, ариутгах татуурга, инженерийн шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх (Улаанбаатар хотын ус хангамжийг урт хугацаанд тогтвортойгоор нэмэгдүүлэх төслийн явц, хувиар);

8. [5.1.5.2] Улаанбаатар хотын ус хангамж, ариутгах татуурга, инженерийн шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх (Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг барих төслийн явц, хувиар);

9. [5.2.1.1] Орон нутаг дахь сум, суурин газрын ус хангамж, ариутгах татуурга, инженерийн шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх (Аймгийн төв, суурин газрын цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, шинээр барих төслийн явц, хувиар);

10. [5.2.1.4] Орон нутаг дахь сум, суурин газрын ус хангамж, ариутгах татуурга, инженерийн шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх (Төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээг хяналт удирдлагын ухаалаг нэгдсэн системд холбох ажлын явц, хувиар);

11. [5.2.3.2] Сум, суурин доторх авто зам, хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламж, гудамж гэрэлтүүлгийн хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн тав тухтай амьдрах орчныг сайжруулах (Сум, суурин доторх гудамж, талбайн тохижилт хийх ажлын явц, хувиар).

3) Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Монгол Улсын Хууль, Монгол Улсын Их Хурал болон Улсын Их Хурлын Байнгын Хорооны тогтоол, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын албан даалгавар, захирамж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж зэрэг 639 шийдвэрийн 7730 зүйл, заалт (давхардсан тоогоор)-аас Барилга, хот байгуулалтын яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хяналтад авсан 86 шийдвэрийн 187 заалтын хэрэгжилтийн явц дунджаар **71.9** хувь байна.

Нийт хяналтад авсан 187 заалтаас 62 заалт буюу 33.2 хувь бүрэн хэрэгжсэн, 55 заалт буюу 29.4 хувь хэрэгжих шатанд, 34 заалт буюу 18.2 хувь хэрэгжилт хангалтгүй, 3 буюу 1.6 хувь хэрэгжээгүй, 33 буюу 17.6 хувь нь хугацаа болоогүй буюу хамааралгүй шалтгаанаар үнэлэгдээгүй байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн төрөл тус бүрээр хэрэгжилтийг авч үзвэл:

№	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн төрөл	Зүйл, заалтын тоо	Хэрэгжилтийн хувь
1.	Монгол Улсын хууль	53	83.9
2.	УИХ-ын тогтоол	23	62.1
3.	УИХ-ын Байнгын хорооны тогтоол	8	58.6
4.	Ерөнхийлөгчийн зарлиг	1	70.0
5.	Засгийн газрын тогтоол	26	68.5
6.	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	63	71.5
7.	Засгийн газрын албан даалгавар	1	70.0
8.	Ерөнхий сайдын захирамж	4	70.0
9.	ҮАБЗ-ийн зөвлөмж	6	62.0
10.	ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл	2	70.0

Дээрх нийт хяналтад авсан 187 заалтаас Монгол Улсын хуулийн 1, Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолын 1, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр үүрэг болгосон 1 заалтын хэрэгжилт 0.0 хувьтай үнэлэгдсэн байна. /Дэлгэрэнгүйг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сангаас харна уу./

Хяналт-шинжилгээний дүнд үндэслэн бүрэн хэрэгжсэн 9, тухайн байгууллагын чиг үүрэгт хамааралгүй 2, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон 1, бусад 12 нийт 4 төрлийн эрх зүйн баримт бичгийн 24 заалтыг хяналтаас хасах шаардлагатай гэж дүгнэв.

----- о О о -----